



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр


Дугаар 1/282

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5/07 дугаар тогтоол "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хаврын тариалалт эхлүүлэхэд стандарт мод (улиас, хайлаас, бургас) худалдаж авах, тариалах, арчилж хамгаалах арга хэмжээнд 14,000,000 төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Л.Батбаяр)-г шилжүүлсүгэй.
2. Дээрх зардалд зарцуулагдах 14,000,000 төгрөг (арван дөрвөн сая)-ийг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 3.1-д тусгагдсан Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 20,0 сая мод хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1412